| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6 | Шилэн дансны мэдээллийг тогтмол хуулийн хугацаанд оруулах | Улсын төсөв | Мэдээний тоо | Төсвийн зарцуулалтын шилэн дансанд байршуулах мэдээллийг хугацаанд нь тогтмол байршуулж ажилласан. | Сар бүрийн 5-ны дотор мэдээллийг оруулсан байна. | Төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг тухай бүрд ЦУОШГазарт хүргүүлэн ажиллаж байна.<br>Шилэн дансад оруулах мэдээллийг сар бүр 5-ны дотор хугацаанд нь байршуулдаг. | 100 |
| 3.6.1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлыг тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд **www.shilen.gov.mn** сайтад байгууллагын чиг үүрэгтэй холбогдолтой мэдээлтийг цаг хугацаанд байршуулах | - | Байршуулсан Мэдээллийн тоо | - | 2025 оноос | Нийтийн мэдээллийн ил тод байдал болон хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilen.gov.mn цахим хуудсанд ажиллах эрх нээлгэн мэдээллээ оруулж эхэлсэн. 1-р улирлын тайланг арга зүй дутуугаас буруу илгээсэн. Холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдон заавар зөвлөмжийг авч II улирал 64%, III улирал 90%-тай тус тус үнэлэгдсэн бөгөөд II, III улиралд аймгийн хэмжээнд шилэн сайтад хөтлөлтөөрөө эхний 5-д шалгарсан. Мөн энэ арга хэмжээний хүрээнд мэдээллийн ил тод байдлын самбар хийж байршуулсан.<br><br>*Зураг. Мэдээллийн ил тод байдлын самбар* | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  *Зураг. www.shilen.gov.mn мэдээлэл байршуулсан үнэлгээний дүн* | |
| **ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ** | | | | | | | |
| 3.7 | Байгууллагын цаасан суурьтай баримт бүрдүүлэх, хадгаламжийн нэгж үүсгэн, данс бүртгэл хөтлөх | Улсын төсөв | Хадгаламжийн нэгж үүсгэсэн тоо | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны албан хэрэг хөтлөлтөөр 11 хадгаламжийн нэгж үүсгэсэн. | Стандартын дагуу нөхөн бүрдүүлэлт хийнэ | -Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг оны эхэнд төвийн даргын тушаалаар батлуулсан. БНШКомиссын хурлыг 2025 онд 2 удаа хийсэн.<br>- Төрийн байгууллагын архив албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэг 2025 онд зохион байгуулагдахтай холбогдуулан Ажлын хэсгийг А/33 тоот тушаалаар томилж, урьдчилсан архив албан хэрэг хөтлөлтийн үзлэгт хамрагдаж 92.9%-тай дүгнэгдсэн.<br>-Сан хөмрөгийн өрөөний хадгалалт, хамгаалалт, чийг дулааны горим, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж, зааврын дагуу тем 14-16, чийг 50-55%-тай цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийдэг.<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйл /23.2, 23.2.1/ “албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж ажилтанаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах” гэсний дагуу Санхүүгийн 2004-2020 оны цалингийн карт, хүснэгт, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн даатгал, төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аж ахуйн материал, бараа материалын тайлан, эд хөрөнгийн тооллого, журнал, шатахууны тооцоо, харилцахын баримт зэргийн 30693 хуудас бүхий 159 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт хүлээж авсан.<br>-Байгууллагын архивт ЦАЗНөлөөлөх үйл ажиллагааны 2021-2024 оны тайлан 169 хуудас бүхий 4 хадгаламжийн нэгж, удирдлагын 2024 оны 9 нэр төрлийн баримт бичгийг 10 хадгаламжийн нэгж болгон хүлээн авч стандартын дагуу баримт бичгийг үүсгэсэн.<br>-Байгууллагын архивт байнга хадгалах 2001-2024 оны 8859 хуудас бүхий 127 ХН, түр хадгалах 2001-2024 оны 49043 хуудас бүхий 201 ХН, 70 жил хадгалах 1983-2024 оны 2800 хуудас бүхий 50 ХН, нийт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 60702 хуудас бүхий 378 ХН хадгалагдаж байна. | |
| 3.8 | Ажилтан, ажиллагсадын хувийн хэргийг зааврын дагуу бүрдүүлэлт хийж, баяжуулах | Улсын төсөв | Ажилтаны тоо | 2024 онд шинээр ажилд орсон 4 албан хаагчийн хувийн хэрэгт байх ёстой баримт бичгийг бүрдүүлэн авсан. | Ажилтан, ажиллагсадын хувийн хэргийг зааврын дагуу бүрдүүлэлт хийгдэж баяжилт хийгдсэн байна | 2025 онд үндсэн 94, шинээр ажилд томилогдсон 2 албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг үүсгэн холбогдох баримт бичгийг /албан тушаалд томилогдсон тушаал, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн анкет, дипломын наториатаар батлуулсан хуулбар, намтар гэх мэт/ бүрдүүлж тусгай хавтсанд хийсэн. | 100 |
| 3.9 | Төрийн албан хаагчийн бүртгэл, тайланг csc.gov.mn цахим хуудсанд өөрчлөлт, | Улсын төсөв | Бүртгэл үүсгэсэн ажилтаны тоо | 2024 онд 96 ажилтаны хувийн мэдээлэл болон цалин, | Албан хаагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэснээр сар бүрийн цалин, | Төрийн албан байгууллагын ажилтны үндсэн мэдээллийг бүртгэх, тухайн ажилтантай холбоотой ажил эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, цалин хөлс, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлгөөнийг заавар, журмын дагуу шинэчлэн бүртгэх | | | нэмэгдэлийн мэдээллийг 1-12 сар хүртэл тухай бүр нь шинэчлэн оруулсан. | нэмэгдлүүд төрийн албаны цалингийн нэгдсэн системд татагдсан байна. | нэмэгдэл цалингийн суурь мэдээллийг оруулах, тайлагнах зориулалттай төрийн албаны ХНУМТ цахим систем байгууллагын албан хаагчдийн мэдээллүүдийг шинэчлэн бүртгэж, нийт ажилчдны хоол, унааны хөнгөлөлтийг ажилтан тус бүрээр, үндсэн цалин, нэмэгдэл цалин хөлсийг тухайн сард нь өөрчлөлт орсон ажилтаны хөдөлгөөнийг тухай бүрд нь шинэчлэн бүртгэл үүсгэн ажиладаг.  *Зураг. Төрийн албаны ХНУМТ-д ажилчдынхаа мэдээлэл шинэчилж оруулсан нь* | |
| 3.10 | Байгууллагад ирсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтийн мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлэх | Улсын төсөв | Өргөдлийн тоо | 2024 онд нийт 52 өргөдөл хүлээн авч хугацаанд шийдвэрлэж ажилласан. | Хугацаа хоцроосон өргөдөл гаргахгүй, хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Иргэд болон албан хаагчдаас 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 58 өргөдөл ирснийг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг холбогдох иргэд, албан хаагчдад өгсөн. Мөн аймгийн Засаг даргын 2017 оны А/131 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын хүрээнд 1-р улирлын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2025.03.25-ны 117 дугаартай, 2-р улирлын шийдвэрлэлтийн мэдээг 2025.06.25-ны 241 дугаартай, 3-р улирлын шийдвэрлэлтийн мэдээг 2025.09.24-ны 387 дугаартай албан бичгүүдээр хугацаанд нь хүргүүлж ажилласан. | 100 |

*Ховд аймгийн УЦУОШТ-ийн 2025 онд хийсэн гүйцэтгэлийн тайлан*

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.11 | ХАСХОМ-ийг холбогдох албан тушаалтан, байгууллагын нийт ажилчид хувь хүний оролгын албан татварын тайланг хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан байх | Улсын төсөв | Ажилтаны хүний тоо | ХАСХОМ-ийг 4 албан тушаалтан, Хүний оролгын албан татварын тайланг 96 ажилтан 2024 оны 2-р сарын 15-аас өмнө хуулийн хугацаанд тайлагнасан. Хэрэгжилт 100% | Хуулийн дагуу ХАСХОМ-ийг 4 албан тушаалтан гаргаж, хуулийн хугацаанд мэдүүлсэн байна. | Авлигын эсрэг хуулийн 10.3 заалт, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.3-т зааснаар 2024 оны ХАСХОМ-ын мэдүүлгээ төвийн дарга болон 3 хэлтсийн дарга нар 2025 оны 2 дугаар сарын 15-наас өмнө хугацаандаа баталгаажуулан мэдүүлсэн. Байгууллагын бүтэц орон тоо шинэчлэгдэж, Хэлтэс гэсэн статус байхгүй болсон учир 2025 онд төвийн дарга ХАСХОМ-н мэдүүлгээ мэдүүлнэ. | 100 |
| 3.12 | Салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол, тушаалын хэрэгжүүлэх тайлан мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлэх. | Улсын төсөв | Тайлангийн тоо | Төрийн мэдээллийн сүлжээ системд шилжсээр 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг цахим байдлаар хүргүүлж ажилласан. | Тухайн шийдвэрүүдийг хяналтанд авч, хэрэгжилтийн тайланг тухай бүр гарган хүргүүлж ажилласан байх | 2025 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэр ирээгүй. Ховд аймгийн засаг даргын захирамж 7, албан даалгавар 1, Жаргалант сумын засаг даргын захирамж 2, БОУАӨСайдын тушаал 4, албан даалгавар 1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол 1, ЦУОШГазрын даргын тушаал 19, Нислэгийн цаг уурын төвийн даргын тушаал 1, Ховд аймгийн Дотоод аудитын хорооны тогтоол 1, төвийн даргын А тушаал 40, Б тушаал 43 нийт 83 төвийн даргын тушаал гарсан байна.<br><br>-Байгууллага хоорондын албан бичгийг https://erp.e-mongolia.mn/ сүлжээг ашиглан 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 203, үүнээс хугацаатай, хариутай 21 бичиг хүлээн авч цаг хугацаанд нь хариуг өгч, 264 албан бичгийг холбогдох байгууллага, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан тушаалтанд хүргүүлсэн.<br><br>*Зураг.Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системээр*<br><br>-2025 онд Аймгийн ЗДТГазраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилт болон Засгийн газар, орон нутагт батлан хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд, ИТХурлын тогтоолын биелэлтийг http://khovd.igovernment.mn хяналт үнэлгээний цахим сүлжээгээр цаг тухайд нь хүргүүлсэн.<br><br>*Зураг. Аймгийн хяналт- шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан* | |
| 3.13 | Салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчний чадавхийг | Улсын төсөв | Ажилтаны тоо | Төвийн салбар нэгжид 4 ажлын байранд сул орон тоо гарсныг | Ажилчдын мэргэжил мэдлэгээ дээшлүүлж, ажлын байрны шаардлага | 2025 оны байдлаар 3 ажлын сул орон тоо гарсан. Үүнд: Тэгрэг-Манхан ус судлалын харуулын техникч өөр ажилд шилжин ажиллах, Мөст цаг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэхжүүлэх | | | байгууллагын сайтаар нээлттэйгээр ажлын зар тавьж, орон нутгаас шалгарсан 4 хүнийг сургаж сул орон тоог нөхөж ажиллуулсан. | хангасан боловсон хүчнийг сонгож, бэлтгэсэн байна | уурын өртөөний техникч өөрийн хүсэлтээр, оны сүүлээр Мөнххайрхан өртөөний техникч тэтгэвэрт гарах хүсэлтийн дагуу ажлаас гарч сул ажлын байранд ажилтан авах зарыг байгууллагын албаны цахим хаяг болон фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж, зарын дагуу анхан шатны материалын шаардлага хангасан 2-3 хүнийг хөтөлбөрийн дагуу сарын хугацаанд дадлагажуулан сургаж, шалгалтанд хамгийн өндөр оноо авсан Б.Мөнхцолыг 2025.01.02-ны өдрийн Б/01 тушаалаар Төгрөг-Манхан ус судлалын техникчээр, Мөст цаг уурын өртөөний техникчээр Б.Энхсайханыг 2025.05.01-ний өдрийн Б/13 тоот тушаалуудаар туршилтын хугацаагаар тус тус томилон ажиллуулж байна. Мөнххайрхан өртөөнд Дарханы ХААИС-н цаг уурын инженер мэргэжлээр төгссөн хүнийг 15 хоногийн дадлагажих сургалтын хөтөлбөр гараад хөтөлбөринй дагуу Мөнххайрхан өртөөнд сурч байна.<br>УМ-ийн салбарт ээлжийн 1 синоптик инженерийн сул орон тоон дээр бүтэц орон тооны өөрчлөлтөөр ажлын чиг үүрэг цомготголоор байхгүй болж ирсэн Радарын инженерийг ЦУОШГ-ын УМ-лэх хэлтэсд болон Нисэхийн төвд 2 сар суралцаж тус УМ-ийн салбарт ажиллах эрх авснаар 10 дугаар сарын 1-ээс ажилд орсон. | |
| 3.14 | Ажилчдын ажиллах таатай орчин нөхцөл бүрдүүлэх | Улсын төсөв | Санхүүгий хэмжээ, эд хөрөнгө, бараа материалын тоо | 2024 онд орон нутагт ажиллаж байгаа салбар нэгжүүд сум | БОАЖЯ, ЦУОШГ-р, аймаг орон нутаг, төсөл хөтөлбөрийн байгууллага, цаг | Энэ онд цаг уурын Зэрэг, Дундус, Байтаг, Манхан өртөөний тохижилт үйлчилгээний ажилд зарцуулах төсөв санхүүгийн санал хүсэлтийг тухайн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөгжүүлэх сангаас 6 салбар нийт 38.450 сая төгрөгний санхүү шийдүүлж ажилчдын ажиллах тав тухтай орчин бүрдүүлсэн байна. | уурын өртөө, харуулууд сум орон нутагтайгаа хамтран ажиллаж тодорхой төсөв санхүү шийдүүлж ажилласан байна. | сумдын Засаг дарга нарт хүргүүлснээр орон нутгийн хөгжлийн сангаас дараах төсөв санхүүг шийдүүлэн ажилласан. Үүнд: -Зэрэг цаг уурын өртөөний барилгын дотоод тохижилтонд шаардлагатай 5 сая төгрөгийн санхүүг орон нутгийн хөгжлийн сангаас шийдүүлсэн. Үүнд: 4 том цонх шиллэх, 2 өрөөний хулдаас 40 метр, 4 ширхэг сандал, ор, өртөөний танилцуулгын шүүгээ тавиур, өрөөнүүдийн гэрэл, хөшиг, үзүүлэн самбар зэрэг бараа материалыг авч өрөө байраа тохижуулан өртөөний ажилчдын ажиллах тав тухтай орчинг бүрдүүллээ.  *Зураг. Зэрэг өртөөний дотоод тохижилт хийсэн нь* -Дунд-ус цаг уурын өртөөний барилгын гадна доторх засварын ажлыг 10 сая төгрөгний санхүүжилтийг сумын ОНХС-аас шийдүүлж тус өртөөний өрөөнүүдийн /4 өрөө/ тааз дулаалах, хана, таазыг тусгай зориулалтын хавтангаар доторлох, гадна хаалга солих, нам даралтын зуух тавьж доторх халаалтыг шийдэх зэрэг ажлуудыг хийж, ажилчдын ажиллах тав тухтай орчин нөхцөл сайжирсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Дундус өртөөний засварын ажил хийсэн нь*<br>- Цаг уурын Байтаг өртөөний байранд орон нутгийн санхүүжилтээр 8 сая төгрөгийн цахилгаан халаалт 3 өрөөнд хийлгэж, ажилчид өвлийн улиралд дулаан ажиллах нөхцөл бүрдлээ.<br><br>*Зураг. Өрөөний цахилгаан халаалтын ажил хийгдсэн нь*<br>-Алтай сумын Бодонч-Алтай ус судлалын харуулын ажиглалт хийдэг цэгийн тохижилтонд шаардлагатай 7,743,000 төгрөгийн төсөвв санхүүг орон нутгаасаа шийдүүлж тус харуулын ажиглалтын цэгийн далан уруу орох, гарах хэсэгт 20 метр урттай шатыг хамгаалалтын хашлага, цэг орчимд жижиг оврын авто машин зогсоол хийж тохижуулснаар харуулын техникчийн ажлын аюулгүй ажиллах орчинг бүрдсэн. Мөн цаг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уурын харуулын конторын барилга засварлахад 15.280.000 сая, доторх тохижилтонд сандал ширээ зөөврийн компьютер авахад 3.980.000 сая нийт 27 сая төгрөгний ажлыг хийж, ажиллах орчин нөхцөлөө сайжруууллаа.<br><br><br><br>*Зураг. Алтай сумын цаг уур, усны харуулуудын техникч нар ажиллах орчноо сайжруулхад хийсэн ажлуудыг харуулсан нь*<br>-Цаг уурын Манхан өртөөний хамт олон өөрсдөө 2.0 сая төсөв санхүүгээ гаргаж нийгмийн хариуцлагын хүрээнд өртөөний байрыг цэвэр усны шугамд холбох, дотроо ариун | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэврийн өрөөг тохижуулж, гадна талдаа бохир усны цооног гаргах ажлуудыг хийж, ажиллах орчин нөхцөлөө сайжруулллаа.<br>Мөн өртөөний дотор талын урсгал засвар хийх, ажлын нормын хавцсаа шинэчлэх ажилд нийт 500.000 мянган төгрөгний санхүү гаргаж шийдлээ.<br><br>*Зураг. Хамт олноороо шийдсэн ажлууд*<br>-Төвийн УМ-х салбарын хамт олон санхүүгээ дундаасаа гаргаж суудаг өрөөндөө засвар хийж ажиллах орчин нөхцлөө сайжруулав.<br><br>*Зураг.УМ-ын хамт олон өрөөндөө засвар хийж байгаа нь* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энэ онд салбар нэгжүүд ажиллах орчин нөхцөлөө сайжруулах ажилд ОНХС-аас нийт 52.5 сая төгрөг шийдүүлж ажилласан байна. | |
| 3.15 | Ажилчдын нийгмийн баталгааг хангах, төрийн бодлого баримтлах | Улсын төсөв | Ажилтаны тоо | 2024 онд 5 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарч, ЗГ-ын тогтоолын дагуу 1 удаагийн нөхөн олговор олгогдсон. | 2025 онд 1 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарна. Тэтгэмжийг өөрийнх нь хүсэлтээр 11 сарын төсөвт суулгасан. | 2025 онд бүтэц орон тооны цомхотголоор 1 ажилтан өндөр насны тэтгэвэрт гарах болзол хангасан тул тэтгэвэртээ гарсан. Мөн 1 ажилтан оны сүүлээр тэтгэвэрт гарах санал өгсний дагуу гарна. Энэ жилдээ багтааж 2 хүний тэтгэмжийн зардалыг төсөвтөө тусгуулсан.<br>Цомхотголд орсон 5 хүний ажилгүй болсны 3 сартай тэнцэх хэмжээний тэтгэмжийн мөнгийн хууль эрх зүйн дагуу шийдвэрлүүлэх үүднээс ажлаас гарсан ажилтнуудын шаардлагатай бүх бичиг баримтуудыг ЦУОШГазарт хүргүүлж ажилласан.<br>Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь оны эхэнд төлөвлөгөө гаргаж байгууллагын удирдлагаар батлуулан ажилладаг бөгөөд тухайн жилд хийх 100%-н биелэлттэй ажилласан.<br>Хүүхэд хамгааллын бодлого Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг мөрдөж, байгууллагын дотоод журманд хэд хэдэн зүйлийг тусгаж мөрдөн ажилласан. Үүнд:<br>•Хөдөлмөрийн хуулийн дагуу бага насны хүүхэдтэй ажилтан албан хаагчдад богиносгосон цагаар ажиллах нөхцөл бүрдүүлдэг.<br>•Төрийн албан хаагчийн гэр бүлдээ гаргах цаг завыг зохицуулж 0-16 насны хүүхдийнхээ төрсөн өдрийг тэмдэглэхэд хагас өдрийн цалинтай чөлөөг давхардсан тоогоор 29 ажилтанд олгож ажиллажээ.<br>•Хүүхдийнхээ эрүүл мэндэд нь | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | анхаарч 0-16 насны хүүхдээ эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ өгөхөд хагас өдрийн цалинтай чөлөөг давхардсан тоогоор 23 ажилтанд олгосон байна.<br>•Бага насны / 0-3 нас / хүүхдээ эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тохиолдолд эцэг эхчүүдэд цалинтай чөлөөг өдрийн 8 цагийн ажилчдад ажлын 5 хоног, ээлжээр ажилладаг ажилчдад ажлын 3 хоногоор нийт 5 ажилтанд олгож ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэж ажилласан байна. Ажилтан, албан хаагчдын гэр бүлээс ЕБС-ийн 12 дугаар анги төгсөж байгаа хүүхдүүдэд баяр хүргэж, байгууллагын зүгээс дурсгалын зүйл гардуулан өгч ЭЕШ –нд нь амжилт хүсдэг үйл ажиллагаа жил бүр уламжлал болон явагддаг. 2025 онд ажилчдын 3 хүүхэд 12 дугаар анги төгссөн.<br><br>*Зураг. ЕБС-г төгсөж байгаа хүүхэдүүдэд төвийн зүгээс хүндэтгэл үзүүлж байгаа нь* | |
| 3.16 | Төрийн албаны залгамж халаа, мерит зарчмыг баримтлах | Улсын төсөв | Ажилчдын тоо /Ажилд орсон, дэвшиж ажилласан/ | Ажлын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, шатлан дэвшүүлэх зарчим баримтлан 2024 онд 4 ажилтанг шатлан | Салбар нэгжид ажлын байрны сул орон тоог нөхөхдөө мэргэжлийн ажлын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, шатлан дэвшүүлэх зарчим баримтлан | -ХАА-н цаг уурын ахлах техникч Ж.Жаргалзаяа нь 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Б/50 дугаар тушаалаар өндөр насны тэтгэвэрт гарч, Ховд өртөөний дарга О.Шинэ-одыг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Б/53 дугаар тушаалаар шатлан дэвшүүлж ХАА-н цаг уурын ахлах техникчээр, Ховд өртөөний | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэвшүүлэх зарчимаар ажилд томилсон. | ажиллана. | техникч Л.Нямцэцэгийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Б/54 дугаар тушаалаар Ховд өртөөний даргаар тус тус шатлан дэвшүүлж төрийн албаны тогтвортой залгамж халааг бүрдүүлэн мерит зарчмаар томилон ажиллуулсан.<br>-ЦУОШГ-ын даргын А/162 дугаар тушаалаар төвийн ХААЦУ-ын салбарын 2 ахлах техникч, цаг уурын салбарын 1 техникч, ус судлалын салбарын 1 ахлах техникч, Улаан ам усны харуулын техникч, мөстөл судлалын салбарын ахлах техникч, радар хариуцсан инженер, АМСЗ-гч 0.5%, ЦАЗН-л салбарын инженер 0.5% тус тус цомхотголд орсон. Төвийн дарга дотроо зохицуулалт хийж ус судлалын ахлах техникч байсан ажилтанг, Мөстөл судлалын инженерээр, АМСЗ-гч тэтгэвэрт гарах болзол хангасан тул тэтгэвэртээ гарч, ЦАЗХ-н ерөнхий инженер, МСЗ-ийн ажлын чиг үүргийг дагуу, цаг уурын ахлах техникч байсан ажилтанг Ховд өртөөний техникчээр ажиллуулахаар зохицуулалт хийсэн. Мөн төвийн Ховд өртөөний дарга жирэмсний амралт авсан тул ХААЦУ-н ахлах техникчээр ажиллаж байсан ажилтанг томилон ажиллуулж байна. | |
| 3.17 | Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын сургалт, семинар, зөвлөгөөнийг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, ажилчдыг сургаж чадавхижуулах | Улсын төсөв | Сургалтанд хамрагдсан ажилтаны тоо | 2024 онд дээд газраас зохион байгуулсан сургалтанд 4 ажилтан хамрагдсан. | ЦУОШГ-ын сургалтын хөтөлбөрийн дагуу | ***Дээд газраас:*** Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд Улаанбаатар хотод 2025 оны 4 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтанд төвийн дарга А.Энхзаяа оролцсон.<br>- Удирдлагын академиас зохион байгуулсан “Удирдах ажилтны ур | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чадвар, манлайлал” сэдэвт 16 цагийн сургалтанд төвийн дарга 4 дүгээр сарын 10-11 өдрүүдэд сууж ҮНЭМЛЭХ авсан.<br><br>*Зураг. Сургалтын үнэмлэх авсан нь*<br><br>- Төвийн дарга БНХАУлс, Монгол Улс хоёрын хамтын ажиллагаа, хоёр орны цөлжилттэй тэмцэх ногоон хөгжлийн хүрээнд 2 орны хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр зохион байгуулагдсан сургалтанд Ховд аймгаас ЗД орлогч дарга, Байгаль орчны газрын дарга, мэргэжилтэн, Онцгой байдлын газрын дарга нарын хамт 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрүүдэд батлагдсан хөтөлбөрийн дагуу Ланжоу болон Шиншин хотод суралцаж гэрчилгээ авсан. Тус сургалтаар Хятад улсын уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, сааруулахад авч хэрэгжүүлж буй ажлын талаар онолын болон бодит сургалтыг мэргэшсэн мэргэжлийн судлаач багш нараар заалгахаас гадна Хятад орны түүх соёл, төр засгаас ногоон хөгжлийн талаар барьж буй зарим бодлого үйл ажиллагаатай танилцсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Сургалтын гэрчилгээ*<br><br>-ЦУОШГ-аас зохион байгуулсан “Тэсрэх бодис, тэсрэх материалтай харьцах ажилтан”-ны эрхийг сунгуулах сургалтанд төвийн ЦАЗН-н ерөнхий инженер Б.Отгонтөмөр, Багажийн инженер Д.Төрмөнх, техникч жолооч С.Нямаахүү нар 4 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд хамрагдаж гэрчилгээ авсан.<br><br><br><br>*Зураг. Тус сургалтанд орлцогчид, үнэмлэх авсан нь*<br>-Аймгуудын УЦУОШТ-ийн ХХХТХ-сан ерөнхий инженер “Шалгалт тохируулгын ажилтан”-ы эрх олгох сургалтад ХХХТХ-сан инженер Д.Төрмөнх 2025.04.28-30-ны хооронд хамрагдаж цаг уурын хэмжилтэнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгслийн шалгалт тохируулын ажил хийх ЭРХ авсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Сургалтанд хамрагдсан ажилтанууд*<br>--ЦУОШГ-ын УМХ-ийн KOICA-ийн төгсөгчдийн Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг мэдлэг түгээх цахим семинарт УИС-ын 1 инженер оролцсон.<br><br>*Зураг. Цахим сургалтанд суусан нь*<br>-ОШХэлтэс, БОХЗТЛабораториоос зохион байгуулсан “MNS 4586:2024” стандартын талаар, “Агаарын бохирдолт PM2.5 тоосонцрын найрлагын шинжилгээгээр эх үүсвэрийн нөлөөллийг тодорхойлох” онлайн сургалтанд 02 сарын 13, 16-нд хамрагдсан.<br>- Агаарын автомат харуулын талаарх 03 сарын 11-нд солонгосчуудын заасан сургалтанд оролцсон.<br>- Улаанбаатар хотод 7 сар, 10 сар,11 саруудад болсон Орчны агаарын чанарын хяналтын системийн тохиргоо, бүтэц үйл ажиллагаа, Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлын хүрээнд Хөрсний экологийн чадавхыг үнэлэх, хөрс, ургамлын ангиллын стандартыг олон улсын стандартад нийцүүлэх сэдэвт сургалтанд БОШЛ-ийн иженерүүд | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамрагдаж гэрчилгээ авсан.<br><br><br>*Зураг.Сургалтанд оролцсон нь*<br><br>-Нисэхийн цаг уурын төвөөс зохион байгуулсан Нисэхийн цаг уурын бодит ажиглалтын мэдээний инженер, техникч нарт зориулсан давтан сургалтанд 2025 оны 04 дүгээр сарын 07-11-ний өдрүүдэд Нислэгийн цаг уурын техникч Э.Оюунтунгалаг хамрагдаж ЭРХ-ээ авсан.<br><br>Гэрчилгээ<br>Эрдэнэцогт Оюунтунгалаг<br>Иргэний агаарын тээврийн нислэгт цаг агаарын бодит ажиглалтын мэдээний үйлчилгээ үзүүлэх инженер, техникчдэд зориулсан 40 цагийн сургалтад хамрагдсан тул ГЭРЧИЛГЭЭ олгов.<br>НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН ДАРГА Б.БАНЬДСУРЭН<br><br>-ЦУОШГ-ын УМХ-ээс Синоптик инженерүүдийн давтан сургалтыг 10 сарын 06-наас 13-ны өдрүүдэд | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахимаар зохион байгуулж 4 инженер хамрагдаж 3 инженер цахим үнэмлэх авсан.<br><br>-Урьдчилан мэдээлэхийн инженерээр ажиллах П.Мягмардорж ЦУОШГ-ын УМХ болон НЦУТ-д 2 сарын сургалтанд хамрагдаж эрх авсны дагуу 10 дугаар сарын 1-ээс УМ-ийн инженерээр ажиллаж байна.<br><br><br><br>*Зураг. УМ-н инженерүүдийн цахим сургалт, гэрчилгээ авсан нь*<br><br>- АДАПТ төслөөс Завхан аймагт зохион байгуулсан "УАӨСДЗ-х үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцах, туршлага солилцох" сэдэвт сургалтанд УАҮ-ний ахлах техникч П.Энхжаргал, техникч Э.Оюунтунгалаг нар оролцсон.<br><br><br>*Зураг. Сургалтанд оролцогчид*<br>***Байгууллагаас:*** Улирлын чанартай ажиглалт эхлэхтэй холбогдуулан Ус судлалын салбарын сургалтыг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахимаар зохион байгуулсан. Тус сургалтанд гол, нуур, мөстлөг судлалын 11 харуулын техникч оролцлоо. Сургалтаар өнгөрсөн оны шинжилгээний ажлын үр дүн, алдаа дутагдалын талаар инженер З.Бататбол, ахлах техникч П.Отгонцэцэг нар болон БОШЛ-ийн инженер С.Жавзанпагма усны химийн сорьц авах, шинжилгээний ажлын талаар хичээл зааж холбогдох арга зүй зөвлөмжийг өгсөн.  *Зураг. Цахим сургалт хийж байгаа нь* -Төвийн нийт ажилчдын НЭГДСЭН СУРГАЛТ арга хэмжээг Зэрэг сумын Зэрэг цаг уурын өртөөнд 2025 оны 05 дугаар сард зохион байгуулж, сургалтанд төвийн инженер, техникчид болон цаг уурын 9 өртөө, цаг уур ус судлалын харуулуудын нийт 60 гаруй ажилтан албан хаагчид оролцсон.  *Зураг. Нэгдсэн сургалтын арга хэмжээ* -Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 11 удаа сургалт авч ажилчдынхаа мэдлэг чадварыг дээшлүүлж ажилласан. Жич: Хавсралт-2 Сургалтын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэлгэрэнгүй тайланд тусгасан.<br>***Орон нутгаас:*** “Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх” сургалтанд тус төвийн эрүүл мэндийн асуудал хариуцсан ажлыг зохион байгуулж ажиллах ажилтан инженер Ж.Ганбаяр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.<br><br>*Зураг. Сургалтанд оролцож гэрчилгээ авсан нь*<br>-“Жендэрийн эрх тэгш байдал ба Уур амьсгалын өөрчлөлт” сэдэвт сургалтанд төвийн хэлтсийн дарга болон УАҮ-ний, ХААЦУ-ын, УМСалбаруудын инженер техникчид оролцсон.<br><br><br>*Зураг. Төвийн албан хаагчид сургалтанд оролцож байгаа нь*<br>-Удирдлагын академиас зохион байгуулсан Нутгийн удирдлагын байгууллагуудын төрийн албан хаагчдад “ДИЗАЙН СЭТГЭЛГЭЭ” сэдэвт 2 өдрийн сургалтанд ахлах | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | техникч О.Шинэ-Од оролцож гэрчилгээ авсан. Мөн ДИЖИТАЛ СОЁЛ сэдэвт сургалтанд инженер Э.Ганцэцэг цахимаар 16 цагийн сургалтан хамрагдаж гэрчилгээ авсан.<br><br><br>*Зураг.Тус сургалтанд хамрагдсан нь*<br>-Аймгийн Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа, Дэлхийн байгаль хамгаалах сан хамтран зохион байгуулсан “ГОЛ МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХИЙГ ТХГН-Н СҮЛЖЭЭНД ХАМРУУЛАХ” сэдэвт хэлэлцүүлэгт төвийн ус судлалын инженер З.Бататбол, мөстөл судлалын инженер Т.Хашэрдэнэ нар оролцсон.<br><br>*Зураг. Сургалтанд оролцсон нь*<br>-Архив албан хэрэг хөтлөлтийнн чадавхжуулах сургалтанд төвийн Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар хамрагдаж сертификат авсан.<br><br><br>*Зураг. Сургалт, гэрчилгээ* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн https://erp.e-mongolia.mn/ систем нэвтрүүлсэнтэй холбогдлуулан "И-Монгол академи" УТҮГ-аас цахимаар зохион байгуулсан сургалтанд Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар, сүлжээний инженер Э.Ганцэцэг нар 2025 оны 03 дугаар сарын 26-нд оролцсон.<br>-Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Үндэсний бичгийн стандарт арга зүйн талаар сургалтанд 2025 оны 04 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Хүний нөөц, бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар оролцсон.<br>-"Төрийн албаны шинэчлэл,үе шат, сургамж" сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт инженер Э.Ганцэцэг 2025 оны 04-р сарын 18-нд оролцсон.<br><br><br>*Зураг. Сургалт*<br>-Аймгийн болон Жаргалант сумын тариаланчдын зөвлөгөөнд зуны улирлын цаг агаарын урьдчилсан мэдээгээр мэдээлэл хийсэн.<br><br><br>*Зураг. Зөвлөгөөнд мэдээлэл өгсөн нь* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Бүсчилсэн хөгжил Төрийн албаны манлайлал" баруун бүсийн зөвлөлгөөн Ховд аймагт 5 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгууллагдаж 5 аймгийн 760 гаруй төрийн албан хаагчид оролцсон үйл ажиллагаанд байгууллагаа сурталчлах самбар үзүүлэн гаргаж, тус зөвлөгөөнд төвийн дарга болон нийт албан хаагчид оролцсон.<br><br>*Зураг. Зөвлөгөөний үйл ажиллагаа*<br>- "Гэр бүлийн хүчирхийлэл" " Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сэдвүүдээр төвийн ажилчдад мэдээлэл хийсэн.<br><br>*Зураг. Сургалт авч байгаа нь*<br>-"Баруун бүсийн хөгжилд Ховд аймгийн оролцоо, аймгийн дунд хугацааны стратеги /2025-2040/" бодлогын баримт бичгийн төслийн хэлэлцүүлэг болж, байгаль орчны салбарын байгууллагууд болон онцгой байдлын газрын нийт 50 гаруй албан хаагч оролцож санал бодлоо солилцлоо. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг.Төвөөс хэлэлцүүлэгт оролцсон нь*<br>-“Бэлчээрийн менежмент, газар тариалангийн усжуулалт, мал үржүүлэг, мал эмнэлэгийн үйлчилгээ, мөшгөх тогтолцооны дэмжлэг болон ХАА-н бодлого сайжруулах санал солилцох суурь судалгаа” сэдэвт төслийн хэлэлцүүлэгт төвийн 2 ажилтан оролцсон.<br><br>*Зураг. Хэлэлцүүлэгт оролцож байгаа нь*<br>-“Гэр бүлийн үнэ цэнэ- Хүүхэд бидний ирээдүй” зөвлөгөөнд байгууллагын эцэг эхийн зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо.<br><br>*Зураг. Зөвөлгөөнд оролцож байгаа нь* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.18 | Туршлага судлах нийт ажиллагсдын нэгдсэн сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Ажилтаны тоо | Тус сургалтыг 2024 онд Мөнххайрхан цаг уурын өртөө зохион байгуулсан | Тушлага судлах сургалтыг жил бүр цаг уурын Зэрэг өртөө зохион байгуулна. Энэ сургалт жил бүр уламжлал болон 6 жилдээ хийгдэнэ | Жил бүр уламжлал болгон явуулдаг туршлага солилцох сургалтыг энэ жил Зэрэг цаг уурын өртөө 05-р сарын 23-ны өдөр "ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЯН БОЛОН ЦУОШГ-Н МЭРГЭЖИЛ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХАРЬЯА САЛБАРУУДЫН АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ, ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ СУРГАЛТ-ӨДӨРЛӨГ нэрийн дор зохион байгуулж явууллаа. Энэхүү арга хэмжээнд ЕБС-н 7-12 дугаар ангийн 50 гаруй хүүхдүүдэд цаг уурын мэргэжлийг ямар сургуульд орж мэргэжил эзэмших талаар мэдээллийг өгч, цаг уурын өртөөн дээр хийгддэг хөтөлбөрт ажлуудыг болон багаж тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг танилцуулж сурагчдад цаг уурын мэргэжлийн чиглэлээр тодорхой ойлголт өгсөн.<br>-Харьяа салбаруудын ажилчдыг чадавхжуулах, салбарын хэмжээнд өртөө, харуулын шинжилгээний хөтөлбөрт ажилд гарч байгаа алдаа дутагдал, тэдгээрийг хэрхэн арилгах, автомат станцууд болон бусад багаж тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, гарч байгаа эвдрэл гэмтлийг засах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч харилцан туршлага солилцсон сургалт арга хэмжээ боллоо.<br>  | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |   *Зураг. Туршлага судлах сургалт- Өдөрлөг арга хэмжээ хийсэн нь* | |
| 3.19 | Ажилтнуудыг мэргэшлийн зэргийн шалгалтад хамруулж, зэрэг олгуулах | Улсын төсөв | Ажилчдын тоо | ЦУОШГ-ын мэргэжлийн зэрэг шалгаруулах комиссд хүргүүлэн зэргийн шалгалтыг өгч, үүнээс 3 инженер, 8 өртөө харуулын техникч, 6 ус судлалын харуулын техникч нийт 17 албан хаагч зэргийн шалгалтанд тэнцэж 2024 оноос зэргийн нэмэгдэлийг авсан бөгөөд нийт 51 ажилтан зэргийн нэмэгдэл авч байна. | Мэргэжлийн зэргийн нэмэгдэл цалинг журмын дагуу олгосон байна. | БОАЖ-ын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 8-р сарын 29-ны А/421, А/115, А/170 дугаар тушаалын 1-р хавсралтаар “УЦУОХШ-ний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ын дагуу 1-р зэрэг-1, 2-р зэрэг-4, 3-р зэрэг- 40, нийт 45 албан хаагч 2025 оны эхний хагас жилийн байдлаар зэргийн нэмэгдэл цалинг олгоод ажиллаж байсан.<br>Төвийн мэргэшлийн зэргийн ажлын хэсэгт 5 ажилтан мэргэшлийн зэргийн хугацааг сунгаж өгөх талаар өргөдөл ирсний дагуу ажлын хэсэг хуралдаж, УЦУОХШ-ний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журмын 3 дугаар бүлгийн 3.7 дахь заалтанд 50-иас дээш насны ажилтанд давтан шалгалтаас чөлөөлж, тухайн зэргийг үргэлжлүүлэн олгож болно гэсэн заалтыг хангаж байгаа тул шалгалт авахгүйгээр мэргэшлийн зэргийг үргэлжлүүлэн олгуулах тухай дүгнэлт гаргаж төвийн даргад өгсөн. Ажлын хэсгийн дүгнэлтийг үнэслэн төвийн даргын тушаал гарч 11 дүгээр сараас дээрх ажилчид мэргэшлийн зэргийн нэмдлийг авч эхэлсэн. | 100 |

*Ховд аймгийн УЦУОШТ-ийн 2025 онд хийсэн гүйцэтгэлийн тайлан*

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.20 | Ажлын үр дүн гаргасан албан хаагчдыг шагнаж урамшуулах, төрийн одон медальд тодорхойлох | Улсын төсөв | Ажилтаны тоо | 2024 онд “Хөдөлмөрийн хүндэт медаль”-р 1, БОЯамны “Тэргүүний ажилтан”-аар 20, БОАЖЯамны “Жуух бичиг”-ээр 6, нийт 32 албан хаагч шагнагдсан. | Шагналд тодорхойлох журмын дагуу ажилтнуудыг шагнаж урамшуулах, төрийн одон медальд тодорхойлж ажиллах. | Мэргэжлийн тэмдэглэлт өдрийг тохиолдуулан 2025 оны 3 дугаар сарын 23-нд тус төвийн жолооч С.Нямхүү, Үйлчлэгч Д.Наранцэцэг, БОШЛ-н инженер Г.Амарзаяа, Зэрэг өртөөний техникч Г.Хүдэрзаяа, Манхан өртөөний техникч Т.Батмөнх, Байтаг өртөөний техникч Б.Мөнхдэлгэр, Бодонч-Алтай ус судлалын харуулын техникч Н.Бүргэд, Дуут ХАА-н харуулын техникч Ш.Баянмөнх нарын 8 албан хаагч ЦУОШГазрын “Жуух бичиг”-ээр шагнагдсан. | 100 |
| 3.21 | УЦУОШТ-ийн нийт ажиллагсдын нийгмийн асуудлыг сайжруулахад анхаарч зарим асуудлыг Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журманд тусган шийдвэрлүүлэх | Улсын төсөв | Ажилчдын тоо, зарцуулалт төгрөгөөр | Байгууллагын дотоод журамд заасны дагуу төвийн нийт ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарим асуудлыг зохион байгуулж, 2024 онд нийт 17.665.000 төгрөгийн тусламж дэмжлэгийг байгууллагын хамтын сангаас үзүүлж ажилласан. | Байгууллагын дотоод журамд заасны дагуу ажилчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж ажилласан байна. | Байгууллагын дотоод журамд заасны дагуу төвийн нийт ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарим асуудлыг зохион байгуулж, энэ жилийн байдлаар эрүүл мэндийн шалтгаанаар эмчилгээ сувилгаанд явсан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, ар гэрт гачигдал гарсан, хурим найр, ажилчдын гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн, бусад үйл ажиллагаанд нийт 17.739.500 төгрөгийн тусламжийг хамт олны хуримтлалын “Хамтын сан”-гийн журмын дагуу шийдэж, тусламж дэмжлэг үзүүлсэн байна. | 100 |
| 3.22 | Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх хүрээнд байгууллагын ёс зүйн дэд хороо нь хуулийг хэрэгжүүлэх ажлыг | Улсын төсөв | Албан хаагчийн тоо | Төвийн даргын 2024 оны 01 дугаар сарын 02-ний А/03 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг | Ажилчдынхаа ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах | -Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог оны эхэнд 7 хүний бүрэлдэхүүтэй байгуулж, тус хороо нь тухайн онд хийгдэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж, ажилчдыг соён гэгээрүүлэх сургалт сурталчилгаа явуулах үйл | 100 |

***Ховд аймгийн УЦУОШТ-ийн 2025 онд хийсэн гүйцэтгэлийн тайлан***

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | шинээр байгуулан ажиллаж байна. 2024 онд төвийн Ёс зүйн зөвлөлөөс 4 удаа ТАХ-ийн ёс зүй, харилцаа хандалгын талаар сургалт зохион байгуулсан. | Албан хаагч бүртэй Ёс зүйн хариуцлагын гэрээ байгуулах<br>Нийт албан хаагчид ёс зүйн зөрчилгүй ажилласан байх | ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хорооны ажлын албанаас байгууллагуудын дэд хорооны дарга, нарийн бичиг, гишүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар зохион байгуулж сургалтанд тус төвийн ёс зүйн дэд хорооны дарга Ц.Дэлгэр, нарийн бичиг Мягмардорж, гишүүн Баярмаа, Ганбаяр, Төрмөнх, Бахатбол, Цацралтуяа нар оролцсон. Мөн ТАХ-ийг ёс зүйн чиглэлээр олон сургалт яаж авах талаар судалсны үндсэн дээр “7:4:10” сургалт, мэдээллийн цагийн “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сэдвээр Ёс зүйн хорооны гишүүн, АШУҮИС-ийн дэд профессор, доктор М.Цэрэнбат зочин багшаар цахимаар мэдээлэл хичээл заалгасан нь маш үр дүнтэй сургалт болсон.<br><br>*Зураг.Цахим сургалт*<br>-Төвийн салбар нэгжид ажилд шинээр орж байгаа ажилтаны сургалтын хөтөлбөрт ТАХ-ийн ёс зүйн тухай хууль, УЦУОХШ-ний ажлын технологийн сахилгын дүрэм зэрэг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэвүүдээр хичээл ордог болсон. Нийт ажилчдын сургалтаар “ТАХ-ийн ёс зүйн талаар” сэдвээр төвийн Ёс зүйн хорооны дарга мэдээлэл өгсөн.<br><br><br>*Зураг. Сургалт авсан сэдвүүд нь*<br>-Шинээр ажилд орж байгаа ажилтантай Ёс зүйн хариуцлагын гэрээ байгуулан ажилладаг.<br>-Аймгийн ТА-ний Ховд аймаг дахь зөвлөлийн даргаар “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага /MNS7068:2025/-ыг төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудад нэвтрүүлэхэд анхаарах асуудал” ТАХ-ийн ёс зүйн талаар төвийн ажилчид мэдээлэл авлаа.<br><br>*Зураг. Сургалт авч байгаа нь* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Монгол улсын Ёс зүйн хорооноос ХҮНДЭЛЬЕ-ЭНЭРЬЕ Ёс зүйн нөлөөллийн сарын аян-2025 хүрээнд зохион байгуулсан “Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал” сэдвээр Ёс зүйн хорооны ажлын албаны дарга Н.Ганбаатарын цахимаар хийсэн сургалтанд төвийн хамт олон болон орон нутгийн ажилчид хамрагдсан.<br><br>*Зураг.Сургалтанд хамрагдсан нь*<br>2025 онд байгууллагын нийт албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргаж, хариуцлага тооцуулсан ажилтан байхгүй. | |
| 3.23 | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчилгүй ажиллах | Улсын төсөв | Сургалтын тоо | Хүний амь нас, эрүүл аюулгүй байдлын хангах, зөрчилгүй ажилласан байна Хоргүйжилтийн сүү, тусгай хэрэгсэлээр хангах | Ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллах | УЦУОШТ-ийн ус судлалын харуулын техникч, мөстөл судлалын техникч нарын 2025 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн сургалтаар ХАБ хариуцсан инженер Б.Отгонтөмөр усанд болон нууранд, өндөр ууланд ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар хичээл зааж ажлын арга зүйгээр ханган холбогдох заавар | 100 |

*Ховд аймгийн УЦУОШТ-ийн 2025 онд хийсэн гүйцэтгэлийн тайлан*

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүрэм журмыг танилцуулан хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангуулснаар хөдөлмөрийн эрсдэл гараагүй.<br>ЦУОШГ-аас зохион байгуулсан ЦАЗНөлөөлөх ажлын тэсэрч дэлбэрэх аюулгүй ажиллагааны талаарх Тэсэлгээний сургалтанд төвийн ЦАЗНөлөөлөх салбарын ерөнхий инженер Б.Отгонтөмөр, инженер Д.Төрмөнх, техник жолооч С.Нямаахүү нар оролцож, ЦАЗН үйл ажиллагааны үеэр гарсан эрсдэл байхгүй.<br>Мөн Ус судлалын БОШЛ-ийн урвалж техникчид усны шинжилгээ авах ажилд уусмалтай ажиллах аюулгүй ажиллагааны дагуу зөв харьцаж урвалж бэлтгэх, шинжилгээ хийх зааврыг лабораторийн эрхлэгч инженер нар тогтмол зааварчилж аюулгүй ажиллагааны дэвтэрт гарын үсэг зуруулан албажуулан ажилладаг.<br>-Мөстөл судлалын инженер шинээр ажилд орж тус инженер өөрөө Цамбагарав уулын мөстөлийн хавтгайд байгаа шонгуудын тоололт 9 дүгээр сард авах үеэр өндөр ууланд болон цас мөсөнд ажиллах аюулгүй ажиллагааны дүрэм журмыг танилцуулж гарын үсэг зуруулж ажилладаг. | |
| 3.24 | Ховд аймагт цаг уурын алба үүсэж хөгжсөний 90 жилийн ойг угтсан ажил зохион байгуулах | - | Саналын тоо | Нийт ажилчдыг саналыг тусгах Нэгдсэн төлөвлөгөө гаргах | 2026 онд тохиох 90 жилийн ойг угтаж хийх ажлын төлөвлөгөө гаргаж, ойн арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлууд | Ховд аймагт цаг уурын алба үүсэж хөгжсөний 90 жилийн ой 2026 онд тохиох бөгөөд ойн арга хэмжээг угтсан ажлын төлөвлөгөөг гаргаж, гаргасан төлөвлөгөөний дагуу ажлуудаа салбар нэгжүүд хуваарилан аваад ажиллаж байна. | 50 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тодорхой болж, эхнээсээ хийгдэж эхэлсэн байна. | -Тодорхой хандив үүсгээд ажиллаж байгаа ба 2025 онд төлөвсөн ажил 50%-ийн биелэлтэй ажиллаж байна. | |
| **НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ-3.1. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ** | | | | | | | |
| 3.1.1 | Байгууллагын болон нийт албан хаагчдын жилд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, батлуулах | Улсын төсөв | Төлөвлөгөөний тоо | Журмын дагуу гаргаж хийсэн | Байгууллагын ХЭГД-ын 100-4-р хавсралт, албан хаагчид 98-р 2-р хавсралтаар | Ховд аймгийн УЦУОШТөвийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ХЭГ-ын даргын 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу, албан хаагчдын төлөвлөгөөг ХЭГ-ын даргын 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу 96 ажилтан 2025 онд хийж гүйцэтгэх ажлынхаа төлөвлөгөөг хийж байгууллагын даргаар баталгаажуулж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 3.1.2 | Байгууллагын даргын дэргэдэх Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр батлах, төрийн албан хаагчдад хяналт тавих үйл ажиллагааг нь эхлүүлэх | - | Гишүүдийн тоо | Зөвлөл 7 бүрэлдэхүүнтэй ажилласан | Байгууллагын даргын дэргэдэх Зөвлөл нь ямар нэгэн шийдвэрийг үнэн зөв гаргаж, зөвлөх үүрэгтэй ажиллана | Нийт ажилчдын хурлаар даргын дэргэдэх зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан байгууллагын үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, холбогдох асуудлыг зөвлөлөөр хэлэлцүүлж байгууллагын даргад зөвлөх үйлчилгээ үзүүлэн шийдвэрийг гарган ажилладаг. Энэ оны эхний 11 сарын байдлаар даргын дэргэдэх зөвлөлийн хурлыг 10 удаа хуралдсан байна. | 100 |
| 3.1.3 | Албан хаагчдын улирал, хагас, бүтэн жилээр хийсэн ажлыг үнэлж дүгнэх, үнэлгээ өгөх | Улсын төсөв | Ажилтаны тоо | Журмын дагуу албан хаагчид 98-р 5-р хавсралтаар 95 ажилтан улирал бүр тайлангаа гаргаж, үнэлгээ авч ажилласан | Журмын дагуу албан хаагчид 98-р 5-р хавсралтаар 95 ажилтан улирал бүр тайлангаа гаргаж ажиллана. | Байгууллагын нийт ажилчдын 2024 оны нийт ажилчдын ажлын тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгч нийт 60 ажилтанд ур чадварын урамшууллыг албан тушаалын үндсэн цалингийн 10-25% хүртэл хувиар 3 сарын хугацаатай олгосон. | 100 |
| 3.1.4 | Байгууллагын | Улсын | Тайлангийн тоо | Журмын дагуу | Байгууллагын | ЦУОШГ-ын даргатай болон аймгийн | 100 |

*Ховд аймгийн УЦУОШТ-ийн 2025 онд хийсэн гүйцэтгэлийн тайлан*

